



**МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 02 өдөр

Дугаар A/25

Улаанбаатар хот

**Хөдөлмөрийн дотоод журмыг
шинэчлэн батлах тухай**

Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 130 дугаар зүйлийн 130.1, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Нэг хот- Нэг стандарт” зорилтот жил болгох А/01 тоот захирамж, “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын Даргын 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн А/03 тоот тушаалаар батлагдсан хөдөлмөрийн дотоод журамд 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс дараах нэмэлт өөрчлөлт оруулсугай. Үүнд:

1.1. Гуравдугаар бүлэгт “3.21-д Газрын үйл ажиллагаанд хэрэглэгдэх стандартуудыг дагаж мөрдүүлэх”

1.2. Дөрөвдүгээр бүлгийн “ 4.23-т Албан тушаалын тодорхойлолтын хүрээнд дагаж мөрдөх стандартуудыг өдөр тутам үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах” гэсэн заалтуудыг нэмэх

Хоёр. Дээрх нэмэлт, өөрчлөлтийг байгууллагын нийт алба хаагчдад танилцуулан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хууль, Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн /З.Зулгэрэл/-д үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт мэргэжилтэн, албан хаагчдад даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ЦОГТГЭРЭЛ

215030373